



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2022 оны 11 сарын 14 өдөр

Дугаар Б/111

Ховд


Ажил хавсран, түр орлон гүйцэтгэгч  
томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.4, 67.5 дахь заалт, Төрийн албаны тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.2 дахь заалт, 43 дугаар зүйлийн 43.3.4, 43.4 дэх заалт, Засгийн газрын 2019 оны 09 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам"-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн Боловсрол, шинжлэх ухааны асуудал хариуцсан мэргэжилтэн Жамьянбазарын Батбаярын албан үүргийг Эрүүл мэндийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн С.Доржид 2022 оны 11 дүгээр сарын 14-ний өдрөөс эхлэн 2023 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийг хүртэл ажил хавсруулан түр орлон гүйцэтгүүлсүгэй.

2. Нийгмийн бодлогын хэлтсийн Эрүүл мэндийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн С.Доржийн нэмэгдэл хөлсийг үндсэн цалингийн 40 хувиар тооцож олгохыг Санхүү, аж ахуйн тасгийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч (Б.Нямдэлгэр)-д зөвшөөрсүгэй.

ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН  
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  
Б. БАЯРСҮХ



8400 03 0902  
Tush B/114 Ba